

СҮХБААТАР АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗРААС
2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.09.30

Баруун –Урт сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Б/199 тоот тушаалаар тус газрын албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл бүтцийн зураглал шинэчлэн батлагдсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсрууллаа.

Хүүхэд, хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит хийгдэж байна. Дээрх ажлын хүрээнд Үндэсний аудитын газрын ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, ажлын уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар 2024 оны ХТЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гишүүн бүр илтгэл тавьж, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг өгч, санал солилцлоо.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үйлчилгээг сайжруулах, кейс шийдвэрлэлтийг эрчимжүүлэх хүрээнд "Ментор хөтөлбөр"-хэрэгжлээ. Монгол улсын гавьяат багш, доктор, профессор Ментор багш Х.Баавгай, Монгол улсын гавьяат багш, доктор, Ментор багш Б.Жавзанхүү нар Сүхбаатар аймагт ажиллаж Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны өргөтгөсөн хуралдаанд оролцож, гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, санал солилцлоо.

Мөн энэ үеэр аймгийн ЦГ-ын Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөө, Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны Шүүхийн Хүүхдийн өрөө, Түр хамгаалах байрны орчин нөхцөлтэй танилцлаа.

Хүүхдийн эрхийн хууль зүй хороо тайлант хугацаанд 1 удаа хуралдаж, бэлгийн хүчирхийллийн хохирогч болон насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой асуудлыг хэлэлцлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын 2024 оны 3 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийг хэлэлцэж, хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого, шийдвэрүүдийг танилцуулж, цаашид анхаарах асуудал зэргээр сургалт хийсэн ба Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн хууль, Нийтийн албанд нийтийн

болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өглөө.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Дарьганга, Онгон, Наран, Халзан сумдад Хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ хийлээ.

Хоёр:Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр

“Хайрын шүхэр” Төрийн бус байгууллагатай хамтран “бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих нь” сургалтыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилчдад зохион байгуулж, сургалтад 200 гаруй багш ажилчид, эцэг эх асран хамгаалагч нар хамрагдаж, бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хүүхдийг бага насанд нь хөгжлийг дэмжих аргууд сэдэвт сургалтын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн. Мөн Баруун –Урт сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон цэцэрлэгүүдийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өглөө.

Баруун-Урт суманд 2024 оны 7 дугаар сард байгалийн гэнэтийн үзэгдэл болж, үргэлжлэн орсон борооны улмаас айл өрхүүд усанд автаж, гамшиг онцгой нөхцөл байдлын үед дэх хүүхдийн эрхийг хамгаалах журмын хүрээнд Баруун-Урт сумын 9 хамтарсан багийн гишүүдэд сургалт хийж, түргэвчилсэн үнэлгээ хийх арга зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн. Мөн 72 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, хувцасны дэмжлэгийг үзүүлж, аянга цахилгааны улмаас орон гэргүй болсон 1 өрхийн 2 хүүхдэд хичээлийн дүрэмт хувцас болон бусад дэмжлэгийг үзүүлэв.

Сүхбаатар аймаг байгуулагдсны түүхт 82 жилийн ойн баяр наадам 2024 оны 7-р сарын 10, 11-ний өдрүүдэд болж өндөрлөсөн. Баяр наадмын хурдан морины уралдаанд 8-14 насны 167 уралдаанч хүүхэд, 277 хурдан морийг унахаар бүртгүүлсэн бөгөөд уралдааны замд 276 морьдыг унаж хурдлуулсан.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын 100 жилийн ойн баяр наадмын хурдан морины уралдааны үед уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж, 6 насны хурдан морины уралдаанд 1497 морь, сонгомол 3 насны уралдаанд 50 морь уралдсан бөгөөд давхардсан тоогоор 577 уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

Хүүхэд,гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын ажлын хэсэг 2024 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд “Явуулын үйлчилгээ” – ний хүрээнд Онгон Наран,

Дарьганга сумдад ажилласан. Явуулын үйлчилгээгээр Сумдын хамтарсан баг, Сургууль, цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын баг, Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа-хяналт, шинжилгээ-үнэлгээ хийлээ.

9 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хүүхэд хамгааллын шинэ хуулийн танилцуулга, шинэлэг, онцлог заалтууд, Хөдөлмөрийн хуулийн 43.3 - т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, Хүүхдийн сурах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангах, орчны аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, согтуурах, мансуурах, аливаа төрлийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн албан хаагч, баг, зөвлөл, иргэдтэй хамтран зохион байгуулах, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өглөө. Мөн төрөөс олгож буй хүүхдийн мөнгөө авч чадахгүй байгаа 5 тохиолдлыг илрүүлэн хяналтад авч зөвлөгөө өгч, түр зогсоох дүгнэлт 3, үргэлжлүүлэн олгох 2 дүгнэлтийг гаргаж холбогдох газарт хүргүүлэв.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны 4 хүүхдэд танхимаар, 1 хүүхдэд цахим хэлбэрээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан "Үер уснаас урьдчилан сэргийлэх" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын газартай хамтран иргэдийг үер, усанд осолдохоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлах Баруун голын эрэг дагуу эрсдэл өндөр 5 цэгт усны ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах самбаруудыг шинээр байрлууллаа.

Иргэд олноор цуглардаг голын эрэг орчим осол гарч болзошгүй газруудад эргүүл хяналтын үүрэг гүйцэтгэж, 1896 орчим иргэдэд зөвлөгөө, зөвлөмж өглөө.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 3 дугаар улирлын байдлаар нийт 19 дуудлага мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсэн.

Гурав: Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр:

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, эвлэлдэн нэгдэх, хүүхдийн эрхийг хангах асуудлаар шийдвэр гаргахад оролцох, өөрсдийн санал бодлоо илэрхийлэх

нөхцөл боломжийг хангах хүрээнд Дорнод аймгийн Энх хүүхдийн зусланд Сүхбаатар аймгийн 13 сум, ЕБС ийн сурагчдын төлөөлөл, аймгийн Хүүхдийн зөвлөл, оролцооны байгууллага, клубуудын төлөөлөл, өсвөрийн сургагч багш хүүхдүүд нийт 90 хүүхэд багш нарыг хамруулсан. Уг хүүхдийн зуслангийн хөтөлбөрт зорилтот бүлгийн болон хүүхдийн оролцооны байгууллагын төлөөллийг хамруулж, “Соёл,спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг баримтлан ажилласан.

Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамтдаа бүтээе амьдрах ухааны төсөл хөтөлбөр, өртөөчилсөн үйл ажиллагаа, чөлөөт сонголтын хөтөлбөр, open mic оролцогчдын мэндчилгээ, эко аялал, байгаль орчноо хамгаалъя зэрэг арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, байгаль орчноо хамгаалах, найз нөхдөө хүндлэх, өөрийгөө илэрхийлэх дадал чадварыг эзэмшүүллээ.

Хүүхдийн оролцох хөгжих эрхийг хангах зорилгоор Эрсдэлт бүлгийн 12 хүүхдийн уран зургийн дугуйланд хамруулж эхлээд байна. Мөн Хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх “Canvas art day”- д зорилтот бүлгийн 10 хүүхдийн хамруулсан.

Аймгийн хүүхдийн зөвлөлийн тэргүүнийг сонгох ээлжит хурлыг зохион байгууллаа.

Хүүхдийн оролцооны байгууллагын сайн туршлага, оролцоо, хамтын ажиллагааг дэмжих, харилцан туршлага судлах, “Welcome-2” арга хэмжээг зохион байгуулав.

Уг арга хэмжээнд “Аймгийн хүүхдийн зөвлөл”, “Өсвөрийн сэтгүүлч”, “Хүслэн ХОУЗ клуб”-ын төлөөлөл 48 хүүхэд хамрагдсан ба өөрсдийн хэрэгжүүлсэн сайн туршлага хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Хүүхдийн оролцооны байгууллагын санаачилгыг дэмжих, чадавхижуулах, үйл ажиллагааг тогтворжуулах, урам зориг өгөх замаар орон нутагт хүүхэд өсвөр үеийн оролцоог нэмэгдүүлэх “Хамтдаа өөрчилъе” 1.000.000 төгрөгийн санхүүжилттэй төслийн уралдааныг зарлалаа.

Үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энэ талаар хуульд туссан зохицуулалтыг олон нийтэд сурталчлах зорилготой “Найз байя -2” үндэсний хэмжээний аяныг эхлүүллээ.

Дөрөв: Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчлах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх “ХҮЛЦЭХГҮЙ” богино хэмжээний олон ангит киног орон нутгийн телевизээр иргэд олон нийтэд хүргэлээ.

“Уг бичиг-Удмын хэлхээ” аяныг 2024.09.04-2024.10.04 хүртэл хугацаанд өрнүүлж байна. Аяны хугацаанд аж ахуйн нэгж, албан байгууллага алба хаагчдынхаа дунд угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх, өвлүүлэн уламжлуулах түгээн дэлгэрүүлэх ажилд идэвх санаачилгатай ажиллахыг уриаллаа.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлан таниулах, стресс менежмент, хувь хүний сэтгэлзүйн эрүүл мэнд, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл өгөх иргэдийн санал хүсэлтийг сонсох, тэдэнд хүрч үйлчлэх, оролцоог хангах зорилгоор “Төрийн үйлчилгээг малчны хотонд” явуулын үйлчилгээг зохион байгуулж, нийт 400 малчин өрх хамрагдсан.

Гэр бүлийн боловсрол олгох ажлын хүрээнд “Хүүхэд насны сэтгэлзүйн эрүүл мэнд”, “Жирэмсэн болон төрсний дараах сэтгэлзүйн эрүүл мэнд” сэдвээр” Сэтгэлзүйч, Докторант, Фото зурган сэтгэл засалч Г.Маралгуатай хамтран подкастийг бэлтгэж орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөхийн өмнөх тасагт хэвтэж буй 25 эмэгтэйд “Жирэмсэн болон төрсний дараах Сэтгэлзүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгууллаа.

Албан байгууллага, Аж ахуй нэгж түүний дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ин үйл ажиллагааг идэвхжүүлэх, арга зүйн дэмжлэг олгох хүрээнд “Бүтээмжтэй байгууллага -Хариуцлагатай эцэг эх” сургалтыг зохион байгуулж, нийт 15 байгууллагын 20 эцэг эхийн зөвлөлийн гишүүн хамрагдлаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх хүүхэд гэр бүл, нийгмийн бүхий л орчинд хүүхдийн аюулгүй байдлыг

хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалахад эцэг эх, байгууллага, аж ахуй нэгжийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн “Гэртээ эрт харъя” нөлөөллийн аяныг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг илрүүлэх фокус судалгааны үр дүнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын холбоо” - той хамтарсан 12 гишүүнтэй бүлгийн 3-р улирлын ээлжит уулзалтыг “Гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцоо” сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 7038:2024 хүрээнд тус стандартыг гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр болон аймгийн 6 сумын Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд, хамтарсан багийн нарийн бичгүүдэд танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 7 удаа зохион байгуулж, 17 нийгмийн ажилтныг хамруулсан.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар түр хамгаалах байранд 19 иргэнийг аюулгүй байдлын үйлчилгээнд хамрууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.САРАНЧИМЭГ